

БАТЛАВ  
САНЖУУХАНГААТ, ХЭРӨНГӨ  
ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА,  
ДЭД ХУРАНДАА ЯАНТӨМӨР

БАТЛАВ  
ЭМ ЗҮЙН ШИНЖЛЭХ УХААНЫ  
ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ  
Л.ЦЭРЭНДУЛАМ

## ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭ

2020 оны 10 сарын 14 өдөр

№ 158

Улаанбаатар хот

### Нэг. Ерөнхий зүйл

1.1. Энэхүү гэрээг нэг талаас Онцгой байдлын ерөнхий газар /цаашид Захиалагч гэх/, нөгөө талаас Эм зүйн шинжлэх ухааны их сургуулийн харьяа "Синдүра-Мед" эмнэлэг /цаашид гүйцэтгэгч гэх/, харилцан зөвшилцөн Иргэний хуулийн 476 дугаар зүйлийн 476.1, 476.2 дахь хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.8 дахь заалтыг үндэслэн харилцан тохиролцож дор дурдсан нөхцөлөөр энэхүү "Үйлчилгээ үзүүлэх гэрээ" (цаашид гэрээ гэх)-г байгуулав.

1.2. Хамтран ажиллах гэрээг бичгээр байгуулна.

1.3. Энэхүү гэрээгээр коронавируст халдварт (COVID-19)-ын цартахлын голомттой улс орноос ирсэн эмнэлэйн шинж тэмдэггүй иргэнийг түр тусгаарлан эмчийн хяналтанд тусгаарлах, ажиглах үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулна.

1.4. Тусгаарлах, ажиглах байранд халдвартын эрсдэлийг тооцон иргэнийг эмчийн хяналтанд 21 хоног тусгаарлана.

### Хоёр. Талуудын эрх, үүрэг

2.1. Захиалагч дараах эрх, үүргийг хүлээнэ.

2.1.1. Захиалагч тал тусгаарлах, ажиглах байранд тусгаарлах иргэнийг зохих журмын дагуу аюулгүй байдлыг ханган хүргэнэ.

2.1.2. Тусгаарлах, ажиглах байранд тусгаарлах хүний тоог урьдчилан төлөвлөж, аж ахуйн нэгж байгууллагын ажиллагсадад халдвартын сэргийлэлт хяналттай холбоотой зохих мэдээллийг өгч, сургалт зохион байгуулна.

2.1.3. Урьдчилан бэлтгэлийг хангуулах зорилгоор аж ахуйн нэгж байгууллагын гаргасан хүсэлтэд үндэслэн шаардлагатай тохиолдолд урьдчилгаа төлбөрийг шилжүүлж болно. (нийт төлбөрийн 70 хувь хүртэл)

2.1.4. Тусгаарлах, ажиглах байрыг Цагдаагийн байгууллагын хяналтанд байлгаж аюулгүй байдлыг хангана.

2.1.5. Тусгаарлагдсан иргэдийн эрүүл мэндэд хяналт тавих эмч томилон ажиллуулна.

2.1.6. Гэрээний үүргийн хугацаа дуусгавар болсоны дараа төлбөрийн үлдэгдлийн зохих хувийг гүйцэтгэлээр тооцож шилжүүлнэ.



2.1.7. Тусгаарлах, ажиглах байрны өрөөний эд хөрөнгө, тавилга хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг захиалагч тал хариуцахгүй.

2.1.8. Захиалагч тал нь Гүйцэтгэгч талаас үйлчилгээний болон хоолны чанар стандартыг хангуулах зорилгоор шаардлага тавьж болно.

## **2.2. Гүйцэтгэгч тал дараах эрх, үүргийг хүлээнэ.**

2.2.1. 2020 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн Монгол Улсын Шадар сайдын "Үнэ тогтоох тухай" 23 дугаар тушаалд заасан төлбөрийг тусгаарлагдсан иргэдийн тоогоор нэхэмжлэх эрхтэй.

2.2.2. Тусгаарлах, ажиглах байранд ажиллах үйлчилгээний ажилчдыг 21 хоног байршуулан ажиллуулна.

2.2.3. ХӨСҮТ болон бусад эрүүл мэндийн байгууллагад эрүүл мэндийн шалтгаанаар шилжсэн иргэний төлбөрийг байрласан хоногоор тооцон тухайн байгууллагад шилжүүлнэ.

2.2.4. Шуурхай штаб, мэргэжлийн байгууллагаас өгсөн заавар, зөвлөмжийг чанд мөрдөж ажиллана.

2.2.5. Чанар стандарт, аюулгүй байдлын шаардлага хангасан, амт чанар, тэжээллэг хоолоор үйлчилнэ.

2.2.6. Хоол үйлдвэрлэл үйлчилгээний аюулгүй байдлыг хангана.

2.2.7. Хүнний үйлчилгээний ажилтан, ажиллагсдыг ажиглалтанд байгаа хүмүүстэй харьцахгүй байхаар зохион байгуулна.

2.2.8. Үйлчилгээ, хоолны чанартай холбоотой гарсан гомдлыг тухай бүр нь дотооддоо шийдвэрлэн захиалагч талд мэдэгдэж ажиллана.

2.2.10. Захиалагчаас шаардсан мэдээллийг тухай бүрт нь үнэн зөв гаргаж хүргүүлнэ.

2.2.11. Гүйцэтгэгч талууд тэгш эрхтэйгээр үүрэг, хариуцлага хүлээнэ.

## **Гурав. Давагдашгүй хүчин зүйл**

3.1. Гэрээнд оролцогч талуудаас үл хамаарах байгалийн хүчин зүйлийн нелөөгөөр талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж чадахгүй буюу зохих ёсоор биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд энэ талаар 24 цагийн дотор харилцан мэдэгдэх үүрэгтэй бөгөөд түүний улмаас ямар нэгэн хохирол учирсан тохиолдолд талууд хариуцлага үл хүлээнэ.

## **Дөрөв. Хариуцлага**

4.1.1. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлсэн тохиолдолд гэрээг дуусгавар болсонд тооцно.

4.1.2. Хэрэв энэ гэрээнд заасан болон түүнтэй холбогдох асуудлаар маргаан гарвал талууд харилцан зөвшилцлийн замаар шийдвэрлэж чадахгүйд хүрвэл холбогдох хууль тогтоомжийн дагуу шүүх байгууллагаар шийдвэрлүүлнэ.


4.1.3. Энэхүү гэрээг 3 хувь үйлдэж, талууд гарын үсэг зурж, тамга дарснаар гэрээ хүчин төгөлдөр болсонд тооцож, тал тус бүр нэг хувийг хадгална.



## Тав. Төлбөр, төлбөр төлөх нөхцөл

- 5.1 Гэрээний нийт төлбөрийг тооцоо нийлсэний үндсэн дээр тухай бүр тооцох болно.
- 5.2. Энэхүү гэрээний төлбөрийг тусгаарлах байранд иргэдийг байршуулсанас хойш ажлын 10 хоногийн дотор талууд тооцоо нийлж ..... банкны ..... тоот дансанд төлнэ.
- 5.3 Талууд тусгаарлах байрны төлбөрийг зориулалтын дагуу ашиглана.

### Гэрээ байгуулсан:

Захиалагчийг төлөөлж	Гүйцэтгэгчийг төлөөлж
Санхүү, хангарт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, хурандаа   (гарын үсэг)	Захирал Чулуунбаатар овогтой Цэдэнсодном   (гарын үсэг)
Хаяг: Партизан 6, Сүхбаатар Дүүрэг 5-р хороо, Улаанбаатар Төв, Монгол Улс	ХАЯГ: Чингэлтэй дүүрэг, 2-р хороо, Чоймболын гудамж 10-р гудамж, их тойруу-25
Холбоо барих утас: 51-262489,	УТАС:88216655
Э-шуудан: obeg_sankhuu@yahoo.com ХАЯГ: ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР	

